

МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
САЙДЫН ТУШААЛ

2020 оны ... сарын ... өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Журамд нэмэлт, өөрчлөлт
оруулах тухай

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.11 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1.Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн А/208 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрын улсын бүртгэл хөтлөх журам /цаашид “журам” гэх/”-ын 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт 6.2.9 дэх заалт, 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт 7.2.8 дахь заалт, мөн зүйлийн 7.3 дахь хэсэгт 7.3.7, 7.3.8 дахь заалт, 10 дугаар зүйл, 11 дүгээр зүйл тус тус нэмсүгэй:

“6.2.9.эцсийн өмчлөгчийн мэдээлэл.”

“7.2.8.дүрэм, хуульд заасан тохиолдолд гэрээ.”

“7.3.7.улсын бүртгэлээс хасагдаж буй хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ;/эх хувиар/”

“7.3.8.улсын бүртгэлээс хасагдаж буй хуулийн этгээдийн хураалгасан тамга, тэмдгийн тодорхойлолт.”

“Арав.Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийн улсын бүртгэл хөтлөх

10.1.Улсын бүртгэгч Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.6-д заасан хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч /цаашид “эцсийн өмчлөгч” гэх/-ийн мэдээллийн улсын бүртгэл хөтлөхөд энэ журмын “Арав” дугаар зүйлд заасныг баримтална.

10.2.Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан захиргааны байгууллагын хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөхөд энэ журмын “Арав” дугаар зүйл хамаарахгүй.

10.3.Улсын бүртгэгч Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт заасан эрх бүхий этгээдээс гаргасан эцсийн өмчлөгчийн мэдээллийг улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдлийг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын баталсан маягтын дагуу хүлээн авна.

10.4.Энэ журмын 10.3-т заасан өргөдөлд дараах баримт бичгийг хавсаргана:

10.4.1.эцсийн өмчлөгч нь гадаадын иргэн бол паспортын хуулбар;

10.4.2.үргэлжилсэн хэлхээ холбоо бүхий гадаадын хуулийн этгээд бол тухайн хуулийн этгээдийн гэрчилгээний хуулбар, түүний албан ёсны орчуулгын баталгаажуулсан хувь.

10.5.Хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлсэн хуулийн этгээд эцсийн өмчлөгчийн мэдээллээ нөхөн бүртгүүлэхэд энэ журмын 10.3-т заасан өргөдөлд дараах баримт бичгийг хавсаргана:

10.5.1.энэ журмын 10.4-т заасан баримт бичиг;

10.5.2.улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт.

10.6.Өргөдөл гаргагч эрх бүхий этгээд хуулийн этгээдийг улсын бүртгэлд шинээр бүртгүүлэхэд энэ журмын Зургаа, Долоод, хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлэхэд мөн журмын Наймд заасан өргөдөлд энэ журмын 10.3-т заасан маягтыг үнэн зөв бөглөн тус тус хавсарган, эцсийн өмчлөгчийн мэдээллээ улсын бүртгэлд бүртгүүлнэ.

10.7.Улсын бүртгэгч хуулийн этгээдийн дараах эцсийн өмчлөгчийн мэдээллийг хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллийн санд хөтөлнө:

10.7.1.тухайн хуулийн этгээдийн хөрөнгийн дийлэнх хэсгийг дангаараа, эсхүл бусадтай хамтран өмчилж байгаа этгээд;

10.7.2.энэ журмын 10.7.1-д заасан эцсийн өмчлөгчгүй тохиолдолд дор дурдсан этгээд:

10.7.1.1.хуулийн этгээдийн үйл ажиллагааг шууд бусаар удирдаж, тухайн хуулийн этгээдийг өмчилж үр шим, ашиг орлогыг нь хүртэж байгаа;

10.7.1.2.өөрийн эрхээ бусдаар төлөөлүүлэн хийлгэж, тухайн хуулийн этгээдийг өмчилж үр шим, ашиг орлогыг нь хүртэж байгаа;

10.7.1.3.энэ журмын 10.7.1, 10.7.2-т заасан эцсийн өмчлөгчгүй тохиолдолд тухайн хуулийн этгээдийн удирдлагыг хэрэгжүүлж байгаа.

10.8.Энэ журмын 10.7-д заасан “хөрөнгийн дийлэнх хэсэг” гэж Компанийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1 дэх хэсэгт заасан тухайн компанийн нийт хувьцааны гуравны нэг буюу түүнээс дээш хувьцаа, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны А-26 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам”-ын 4.3-т заасан тухайн хуулийн этгээдийн хөрөнгийн 33, түүнээс дээш хувь гэж тус тус ойлгоно.

10.9.Энэ журмын 10.7-д заасан эцсийн өмчлөгчийн дараах мэдээллийг хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллийн санд хөтөлнө:

10.9.1.эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр;

10.9.2.регистрийн дугаар;

10.9.3.иргэний харьяалал;

10.9.4.эзэмшиж байгаа хувьцааны хувь, хэмжээ.

10.10.Улсын бүртгэгч үргэлжилсэн хэлхээ холбоо бүхий хуулийн этгээдийн дараах мэдээллийг хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллийн санд хөтөлнө:

10.10.1.хуулийн этгээдийн нэр;

- 10.10.2.регистрийн дугаар;
- 10.10.3.харьяалах улсын нэр;
- 10.10.4.эзэмшиж байгаа хувьцааны хувь, хэмжээ.

10.11.Энэ журмын 10.10-т заасан үргэлжилсэн хэлхээ холбоо бүхий хуулийн этгээдийн мэдээллийг энэ журмын 10.7-10.10-т заасан эцсийн өмчлөгч хүнийг бүртгэх хүртэл задална.

10.12.Хуулийн этгээд нь эцсийн өмчлөгчийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтөө Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэгт заасан хугацаанд улсын бүртгэлийн байгууллагад мэдүүлж, бүртгүүлнэ.

10.13.Улсын бүртгэлийн байгууллага хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг хуулиар тусгайлан эрх олгосон байгууллагын эрх бүхий албан тушаалтны хүсэлтийн дагуу гаргаж өгнө.”

“Арван нэг.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ олгох

11.1.Улсын бүртгэлийн байгууллага хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэснийг нотолсон улсын бүртгэлийн цахим гэрчилгээг цахим мэдээллийн санд байршуулж болох бөгөөд өргөдөл гаргагчийн хүсэлтээр улсын бүртгэлийн гэрчилгээг үнэт цаасан дээр хэвлэж, баталгаажуулан олгоно.

11.2.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ доорх төрөлтэй байна:

- 11.2.1.хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ;
- 11.2.2.хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газрын гэрчилгээ;
- 11.2.3.гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газрын гэрчилгээ.

11.3.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ/цаашид “гэрчилгээ” гэх/-нд дараахь мэдээллийг тусгана:

11.3.1.улсын бүртгэлд бүртгэсэн он, сар, өдөр, хувийн хэргийн болон регистрийн дугаар;

11.3.2.хуулийн этгээдийн нэр, хэлбэр, үүсгэн байгуулах баримт бичгийн нэр, үүсгэн байгуулсан шийдвэрийн нэр, дугаар, он.сар.өдөр;

11.3.3.хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, удирдах зөвлөлийн дарга, гүйцэтгэх захирал, хоршооны дарга гэх мэт холбогдох хуульд заасан эрх бүхий этгээдийн албан тушаалын нэр, овог, нэр, бүртгэсэн он.сар.өдөр;

11.3.4.улсын бүртгэлд бүртгүүлсэн эцсийн өмчлөгчийн тоо, бүртгэсэн он.сар.өдөр;

11.3.5.үйл ажиллагааны код, чиглэл;

11.3.6.үйл ажиллагаа эрхлэх хугацаа, үүсгэн байгуулагчийн тоо, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ (мян.төг);

11.3.7.хуулийн этгээдийн хууль ёсны хаяг;

11.3.8.улсын бүртгэлд бүртгэсэн байгууллагын нэр, улсын бүртгэгчийн овог, нэр, гарын үсэг, хувийн дугаар бүхий тэмдэг.

11.4.Хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газрын гэрчилгээ/цаашид “гэрчилгээ” гэх/-нд дараахь мэдээллийг тусгана:

11.4.1.Иргэний хуульд заасан салбар, төлөөлөгчийн газрын тодорхойлолт, тухайн хуулийн этгээдийн хувийн хэргийн болон регистрийн дугаар, салбар, төлөөлөгчийн газрын нэр;

11.4.2.салбар, төлөөлөгчийн газар байгуулсан эрх бүхий этгээдийн нэр, шийдвэрийн нэр, дугаар, он.сар.өдөр;

11.4.3.салбар, төлөөлөгчийн газрын захирал, дарга, эрхлэгч гэх мэт холбогдох хуульд заасан эрх бүхий этгээдийн албан тушаалын нэр, овог, нэр, бүртгэсэн он.сар.өдөр;

11.4.4.үйл ажиллагааны код, чиглэл;

11.4.5.үйл ажиллагаа эрхлэх хугацаа;

11.4.6.салбар, төлөөлөгчийн газрын хууль ёсны хаяг;

11.4.7.улсын бүртгэлд бүртгэсэн байгууллагын нэр, улсын бүртгэгчийн овог, нэр, гарын үсэг, хувийн дугаар бүхий тэмдэг;

11.4.8.улсын бүртгэлд бүртгэсэн он.сар.өдөр.

11.5.Гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газрын гэрчилгээ/цаашид “гэрчилгээ” гэх/-нд дараахь мэдээллийг тусгана:

11.5.1.Хөрөнгө оруулалтын тухай хуульд заасан гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газрын тодорхойлолт, хувийн хэргийн болон регистрийн дугаар, нэр;

11.5.2.гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газар байгуулсан эрх бүхий этгээдийн нэр, шийдвэрийн нэр, дугаар, он.сар.өдөр;

11.5.3.гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газрын гүйцэтгэх захирлын овог, нэр, бүртгэсэн он.сар.өдөр;

11.5.4.үйл ажиллагааны код, чиглэл;

11.5.5.үйл ажиллагаа эрхлэх хугацаа;

11.5.6.гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газрын хууль ёсны хаяг;

11.5.7.улсын бүртгэлд бүртгэсэн байгууллагын нэр, улсын бүртгэгчийн овог, нэр, гарын үсэг, хувийн дугаар бүхий тэмдэг;

11.5.8.улсын бүртгэлд бүртгэсэн он.сар.өдөр.

11.6.Гэрчилгээг дахин олгох тохиолдолд регистрийн дугаар өөрчлөгдөхгүй бөгөөд мэдээлэлд оруулсан өөрчлөлтүүдийг гэрчилгээнд тусгаж, энэ журмын “Арван” нэгдүгээр зүйлд зааснаар улсын бүртгэл хөтөлнө.

2.Журмын дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/Нэгдүгээр зүйлийн 1.4 дэх хэсэг:

“1.4.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт заасан хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрыг тухайн хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагаа явуулах нутаг дэвсгэрийг харьяалах улсын бүртгэлийн байгууллагад бүртгэнэ.”

2/Хоёрдугаар зүйлийн 2.1.11 дэх заалт:

“2.1.11.улсын бүртгэгч баталгаажуулсан болон хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг тусгасан улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, улсын бүртгэлд бүртгэхээс татгалзсан тухай шийдвэрийг цахимжуулан, тухайн хуулийн этгээдийн хувийн хэрэгт хавсаргахаар архивт шилжүүлэх.”

3/Тавдугаар зүйлийн 5.3 дахь хэсэг:

“5.3.Улсын бүртгэгч энэ журмын 5.2-т заасан улсын бүртгэлд бүртгэхээс татгалзсан тухай шийдвэрийг цахимжуулан, тухайн хуулийн этгээдийн хувийн хэрэгт хавсаргахаар архивт шилжүүлнэ.”

4/Долоодугаар зүйлийн 7.1, 7.2 дахь хэсэг, мөн зүйлийн 7.2.1, 7.2.2 дахь заалт:

“7.1.Өөрчлөн байгуулах замаар шинээр байгуулагдсан болон хэлбэр өөрчлөгдсөн хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэхэд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 19, 20, 21 дүгээр зүйлийг баримтална.”

“7.2.Өөрчлөн байгуулах замаар шинээр байгуулагдсан болон хэлбэр өөрчлөгдсөн хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгүүлэхэд дараах баримт бичгийг өргөдөлд хавсаргана:”

“7.2.1.өөрчлөн байгуулах тухай шийдвэр /тогтоол/;”

“7.2.2.хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалт;”

5/Наймдугаар зүйлийн 8.2.2, 8.2.4, 8.2.5, 8.2.11, 8.3.1, 8.3.6, 8.3.12 дахь заалт:

“8.2.2.үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч, гишүүн;”

“8.2.4.үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчийн хувь, гишүүний хувь хөрөнгийн хэмжээ;”

“8.2.11.хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч болон түүний хувьцаа, хувь оролцоо, саналын эрхийн талаарх мэдээлэл.”

“8.3.1.хуулийн этгээдийн нэр өөрчлөх тохиолдолд шинээр олгосон нэрийн баталгаажуулалт, нэр өөрчилсөн тухай өдөр тутмын сонинд зарлуулсан зар;”

“8.3.6.эрх шилжүүлэх тохиолдолд Иргэний хуульд заасан нотариатаар гэрчлүүлсэн холбогдох гэрээ, гэрээслэл, эсхүл өв залгамжлах эрхийн гэрчилгээ;”

“8.3.12. тухайн хуулийн этгээдийн харьяалагдах татварын албаны тодорхойлолт;”

6/Арван нэгдүгээр зүйлийн 11.2.4 дэх заалт:

“11.2.4. хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээг үрэгдүүлсэн бол хүчингүйд тооцсон тухай өдөр тутмын сонинд зарлуулсан зар;”

7/Арван дөрөвдүгээр зүйлийн 14.3 дахь хэсэг:

“14.3. Улсын бүртгэгч энэ журмын 14.2-т заасны дагуу улсын бүртгэлийн мэдээллийн санд засвар, өөрчлөлт оруулахад үндэслэсэн дүгнэлт, шийдвэрийг цахимжуулан, тухайн хуулийн этгээдийн хувийн хэрэгт хавсаргахаар архивт шилжүүлнэ.”

3. Журмын “Долоо” дугаар зүйлийн 7.3 дахь хэсгийн 7.3.1, 7.3.2, 7.3.4, 7.3.5, 7.3.6, 7.3.7 дахь заалтын дугаарыг 7.3.1, 7.3.2, 7.3.3, 7.3.4, 7.3.5, 7.3.6 гэж, “Ес” дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийн 9.2.2, 9.2.3, 9.2.5, 9.2.6, 9.2.7, 9.2.8 дахь заалтын дугаарыг 9.2.1, 9.2.2, 9.2.3, 9.2.4, 9.2.5, 9.2.6 гэж, “Арав” дугаар зүйлийг “Арван нэг” дүгээр зүйл гэж, “Арав” дугаар зүйлийн 10.1, 10.2 дахь хэсгийг “Арван нэг” дүгээр зүйлийн 11.1, 11.2 дахь хэсэг гэж, “Арав” дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн 10.2.1-10.2.5 дахь заалтыг “Арван нэг” дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийн 11.2.1-11.2.5 дахь заалт гэж, “Арван нэг” дүгээр зүйлийг “Арван хоёр” дугаар гэж, “Арван нэг” дүгээр зүйлийн 11.1-11.6 дахь хэсгийг “Арван хоёр” дугаар зүйлийн 12.1-12.6 дахь хэсэг гэж, “Арван нэг” дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийн 11.3.1-11.3.9 дэх заалтыг “Арван хоёр” дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийн 12.3.1-12.3.9 дэх заалт гэж, “Арван хоёр” дугаар зүйлийн 12.4 дэх хэсгийн “11.3-т” гэснийг “12.3-т” гэж, “Арван хоёр” дугаар зүйлийг “Арван гурав” дугаар зүйл гэж, “Арван хоёр” дугаар зүйлийн 12.1-12.3 дахь хэсгийг “Арван гурав” дугаар зүйлийн 13.1-13.3 дахь хэсэг гэж “Арван гурав” дугаар зүйлийн 13.2, 13.3 дахь хэсгийн “12.1-д” гэснийг “13.1-д гэж, “Арван гурав” дугаар зүйлийг “Арван дөрөв” дүгээр зүйл гэж, “Арван гурав” дугаар зүйлийн 13.1-13.3 дахь хэсгийг “Арван дөрөв” дүгээр зүйлийн 14.1-14.3 дахь хэсэг гэж тус тус өөрчилсүгэй.

4. Журмын 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсгийн 7.3.3 дахь заалт, мөн зүйлийн 7.5 дахь хэсэг, мөн хэсгийн 7.5.1 дэх заалт, 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийн 9.2.1, 9.2.4 дэх заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Гарын үсэг